

МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН ХОЛБООНЫ “ХҮНДЭТ ДЭВТЭР”-Т НЭРИЙГ НЬ АЛДАРШУУЛАХ ШАГНАХ ЖУРАМ

НЭГ: Нийтлэг үндэслэл

1. Авто замын салбарыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан, ажлын амжилт, бүтээл гаргасан тэргүүний хүмүүсийг Монголын авто замчдын холбооны “Хүндэт дэвтэр”-т нэрийг бичиж алдаршуулан шагнаж ажиллагсдын ажлын бүтээлийг үнэлэх, салбараараа бахархах сэтгэлгээг төлөвшүүлэхэд энэхүү журмын зориолго оршино.

ХОЁР: “Хүндэт дэвтэр”-т нэрийг бичиг алдаршуулан шагнах үзүүлэлтүүд

2. “Хүндэт дэвтэр”-т нэрийг бичиг алдаршуулахад дор дурьдсан шалгуур үзүүлэлтийг хангасан ажилтнуудыг шагнана. Үүнд:
 - 2.1 Эрхэлсэн ажилдаа амжилт гарган, хамт олноо манлайлан үлгэр дууриал үзүүлж, авто замын салбарт тасралтгүй 20-с дээш жил ажилласан
 - 2.2 Дэвшилтэт шинэ техник технологийг эзэмшин нэвтрүүлж, техник тоноог төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах талаар төсөл боловсруулж, хэрэгжүүлэхэд доривтой хувь нэмэр оруулсан, шинэ санаа санаачлагыг сэдэж, тооцоо судалгаа хийж үйлдвэрлэлд нэвтрүүлэн, мэдлэг чадвараа дайчлан ажилласан
 - 2.3 Байгууллагын ажилтнуудын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, сургаж дадлагажуулахад бодит хувь нэмэр оруулсан, онолыг мэдлэгийг дээшлүүлэх, ажил үйлчилгээнд тодорхой үр дүн өгөхүйц нээлт, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой шинэ техник технологи, шилдэг тэргүүний арга ажиллагааны чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажлын шинэ бүтээл, ном сурах бичиг гаргасан буюу гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын туршлагыг өөрийн орны нөхцөлд тохируулах үйл ажиллагаанд хэрэгжүүлж туршин үр ашигтай болохыг баталсан ажилтнууд

ГУРАВ: Шагналд тодорхойлох, олгох

- 3.1 “Хүндэт дэвтэр”-т нэрийг бичиг алдаршуулан шагнуулах санаачлагыг байгууллага хамт олны хурлаар хэлэлцэж, тухайн ажилтны тодорхойлолтыг МАЗХ-нд ирүүлнэ.
- 3.2 Энэ журмын 2.2, 2.3-т заасан үзүүлэлтээр шагнагдах хүмүүст ажилласан жилийг харгалзахгүй байж болно.
- 3.3 “Хүндэт дэвтэр”-т нэрийг бичиг алдаршуулан шагнуулах хүсэлт тодорхойлолтыг жилд нэг удаа 9-р сард хүлээн авна.

- 3.4 Шагнуулах хүмүүсийн талаар ирүүлсэн санал тодорхойлолт, материалыг МАЗХ-ны удирдах зөвлөлөөр шийдвэрлэж Ерөнхийлөгчийн зарилгаар Замчдын баяраар олгоно.
- 3.5 Дээрх шагналыг жилд 5 хүртэлх хүнд олгох бөгөөд тэгш жил / тав таван жилээр/ тохиож байгаа жилүүдэд 10 хүртэлх хүнд олгоно.
- 3.6 Төрийн болон яам, тусгай газар, хот, бусад байгууллагын шагналаар шагнагдсан ажилтан тухайн жилд дээрх шагналыг давхардан авч болно.

ДӨРӨВ: Шагналыг дагалдах мөнгөн олговорын хэмжээ

- 4.1 "Хүндэт дэвтэр"-т нэрийг бичиж алдаршуулах шагналын мөнгөн олгвор 500.000₮ байна.
- 4.2 "Хүндэт дэвтэр"-ийн дагалдах мөнгөн олговорын хэмжээг өөрчлөх тохиолдолд тухайн жилийн хурлаар шийдвэрлэнэ.

ТАВ: "Хүндэт дэвтэр"-т бичигдэх байдал

- 5.1 Хүндэт дэвтрийн дээд хэсгийн зүүн урд нь "Хүндэт дэвтэр"-т бичигдсэн хүний 6x9 хэмжээний фото зургийг байрлуулж хажууд нь нэрийг нь бичнэ.
- 5.2 Зургийн доод хэсэгт тухайн хүний байгуулсан гавьяа, авто замын салбарт оруулсан хувь нэмэр, ажлын амжилтыг бэхээр цэвэр үзэмжтэй уран бичнэ.
- 5.3 "Хүндэт дэвтэр"-ийн доод хэсэгт шагнуулсан хүмүүсээр гарын үсэг зуруулж батламжилсан "Гэрчилгээ" олгоно.
- 5.4 "Хүндэт дэвтэр"-ийг цахим хэлбэрээр бүрдүүлэн ашиглаж болно.

ДУРСГАЛЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ, ЗАГВАР

Хүндэт дэвтэрт бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээг А5 хэмжээний хатуу, түмэн наст хээтэй суурьтай алтлаг өнгийн цаасан дээр, МАЗХ-ны логог товойлгон хийсэн доорх загвараар хэвлэнэ.

МОНГОЛ АВТО ЗАМЧДЫН ХОЛБОО

ХҮНДЭТ ДЭВТРИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар

..... овогтой

..... танаа

Авто замын салбарт таны оруулсан хувь нэмэр, гавьяа зүтгэлийг үнэлж салбарын түүхэнд тэмдэглэн Монголын авто замдын холбооны "Хүндэт дэвтэр"-т бичиж гэрчилгээ олгов.

ЕРӨНХИЙЛӨГЧ

ЛОГО

200.... он сар өдөр